Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь олон улсын боловсролын сайн туршлага, тэргүүлэх стандартыг Монгол улсад хэрэгжүүлж, улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулан, өндөр мэргэшсэн, нийгмийн хариуцлагатай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, бүтээлч инженерүүдийг бэлтгэх сургалтын үйл ажиллагаа явуулдаг Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Эрхэм зорилгоо “Өндөр зэрэглэлийн, нийгмийн хариуцлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэж, нийгмийн сайн сайхны төлөө судалгаа инновацыг хөгжүүлснээр Монгол улсын хөгжилд хувь нэмэр оруулж, Германы дээд боловсрол, шинжлэх ухааны тэргүүн туршлагыг удирдлага болгож, Монголын соёл, өвд баттай суурилсан байна. Сургалт, судалгаа нь бодит хэрэглээнд чиглэсэн, аж үйлдвэрийн түншлэлд түшиглэсэн байх бөгөөд бүтээлч, шүүмжлэлтэй, нээлттэй сэтгэлгээ, манлайллыг дэмжинэ” гэж тодорхойлсон байна.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь 2025 оны “Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө” -нд 6 стратегийн зорилго, 17 зорилтын хүрээнд нийт 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвлөсөн. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг алба, факультет, нэгжийн төлөвлөгөөний биелэлтийг үндэслэл болгон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулсан гүйцэтгэлийн түвшинд үнэлгээ хийхэд 91 хувийн үр дүнтэй гарсан гэж тайлагнасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь тус сургуулийн төсвийг батлан боловсролын байгууллагуудын гүйцэтгэлд суурилсан төсвийн зарцуулалтын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

ХБНГУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын санамж бичиг, Монгол улсын засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 95 тоот шийдвэрээр үүсгэн байгуулагдсан. Монгол Улсын дээд боловсролын тухай хууль болон Боловсролын тухай хуулийн болон бусад холбогдох хуулийн зохицуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 5 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;

- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай журам шинэчлэн батлагдсан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналт, шалгалтын мэргэжилтэн 2025 оны 1 дүгээр сард чөлөө авсан тул дотоод хяналт хариуцсан ажилтангүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол, Германы хамтарсан ашигт малтмал, технологийн сургуулийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/115 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг”-ийг дагаж мөрддөг бөгөөд тус бодлогын баримт бичиг нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, тус их сургуулийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баримтад өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 164,910.8 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

#### *Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	470,045.5	506,900.5	36,855.0
Авлага	493,247.6	557,127.2	63,879.5
Урьдчилгаа	132,230.8	57,590.4	(74,640.4)
Бараа материал	46,032.0	9,664.2	(36,367.8)
Үндсэн хөрөнгө	16,705,500.3	16,550,863.1	(154,637.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>17,847,056.2</b>	<b>17,682,145.4</b>	<b>(164,910.8)</b>
Өр төлбөр	228,298.9	322,800.8	94,501.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,618,757.3	17,359,344.6	259,412.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>17,847,056.2</b>	<b>17,682,145.4</b>	<b>(164,910.8)</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данснуудад материаллаг дүнгээр өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 506,900.5 мянган төгрөг болж, 36,855.0 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс 2,067,635.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 2,133,617.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 28,911.5 мянган төгрөг, хандив тусламжийн орлого 111,424.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 739,626.5 мянган төгрөг, хүүгийн орлого 4,476.5 мянган төгрөг нийт 5,085,691.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 4,778,730.6 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 270,106.1 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна;
- Авлагын дансны үлдэгдэл 557,127.2 мянган төгрөг болж, 63,879.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд сургалтын төлбөрийн авлага өссөн;
- Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 57,590.4 мянган төгрөг болж, 74,640.4 мянган төгрөгөөр буурсан нь 2024 онд тендер зарласан гал тогооны засвар, тоног төхөөрөмжийн ажлыг хүлээн авч бүртгэлд тусгасан;
- Бараа материал дансны үлдэгдэл 9,664.2 мянган төгрөг болж, 36,367.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 406,497.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс сургалтын хэрэглэгдэхүүн, үйл ажиллагаанд шаардлагатай 13 нэр төрлийн 197 ширхэг 20,325.0 мянган төгрөгийн материал хэрэгсэл, Петростар ХХК-иас шатахууны картын 939.2 мянган төгрөгийн урамшууллыг үнэ төлбөргүй хүлээн авч үйл ажиллагаанд 464,129.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,550,863.1 мянган төгрөг болж 154,637.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 270,106.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авч, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс сургалтын зориулалттай компьютер, ширээ сандал, болон бусад хөрөнгө болон эрдэс судлалын лабораторийн зориулалтаар нийт 225,844.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр

хүлээн авч тайлант хугацаанд 707,799.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэн;

- Тус байгууллага нь 1,500.0 мянган төгрөгийн өртөгтэй Динамик санхүүгийн программ хангамжийг байгууллагын санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн 24,857.9 мянган төгрөгийн өртөгтэй Arc GIS газарзүйн мэдээллийн систем, Matlab, LIMN техникийн схемийн тооцоолох программ, Simatic step 7, Simatic win CC, Матлаб-БУФ гэсэн 6 программ хангамжийг сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж, 37,444.9 мянган төгрөгийн өртөгтэй 187 ширхэг Official Standard 2019 лиценз, 114,894.7 мянган төгрөгийн өртөгтэй 187 ширхэг Windows Pro 10 лиценз ашиглаж байна. Байгууллагын үйл ажиллагаанд 1,410.0 мянган төгрөгийн өртөгтэй Эйбл систем, 2,490.0 мянган төгрөгийн өртөгтэй хүний нөөцийн программ хангамжийг ашиглаж байна. Программ хангамжийн ашиглалт хэвийн, үйл ажиллагаанд бүрэн ашиглагдаж байна;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 322,800.8 мянган төгрөг болж 94,501.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ХХОАТ 20,231.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөгийн дансанд түлш халаалт 30,581.8 мянган төгрөг, бичиг хэрэг 3,871.5 мянган төгрөг, албан томилолт 631.0 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг дансанд байрны түрээс 3,060.0 мянган төгрөг, цахим анги тоног төхөөрөмж 59,372.4 мянган төгрөг, бусад зардал 1,108.0 мянган төгрөг тус тус бүртгэсэн байна. Сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого дансанд 224 оюутны 203,944.7 мянган төгрөгийн бүртгэсэн байна;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 259,412.7 мянган төгрөгөөр буюу тайлант оны үйл ажиллагааны алдагдлын дүнгээр буурсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,440,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,406,116.4 мянган төгрөг, нийт зарлагыг 4,846,116.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж сургуулийн удирдах зөвлөлд хүргүүлсэн байна.

Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 63 дугаар тогтоолоор 2025 оны орлогын доод хязгаарыг 4,846,116.4 мянган төгрөг, зардлын дээд хязгаарыг 4,846,116.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн нэг арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,070,000.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,457,763.6 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 318,352.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,067,635.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 2,133,617.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоор 884,438.9 мянган төгрөг нийт 5,085,691.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,048,836.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,048,836.6 мянган төгрөг буюу 104.2 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал (282,636.2) мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 548,495.7 мянган төгрөг, Хангамжийн бараа материалын зардал 165,888.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 414,734.9 мянган төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 237,903.9 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулж бараа үйлчилгээний бусад зардал 1,481,304.1 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71803	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль- Дээд боловсрол	4,846,116.4	5,048,836.6	(202,720,267.5)	104.2
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,846,116.4	5,021,803.1	(175,686.6)	103.6
83601	Бусад		27,033.5	(27,033.5)	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгааг хянахад дараах тоон үзүүлэлттэй байна. Үүнд:

### Судалгааны үр дүн:

- Сургуулийн Удирдах зөвлөлөөс 2025 онд нийт 87 орон тоо баталсанаас хүний нөөцийн бүрдүүлэлт дунджаар 85.0 хувь буюу нийт 70-73 орон тооны ажилтантайгаар үйл ажиллагаа явуулсан байна. Мөн Монгол, Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь боловсрол сургалтын байгууллага статустай, ЗГ-ын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор МУ-н Консерватор, Үндэсний Батлан Хамгаалах Их Сургуулиас бусад төрийн өмчит их дээд сургуулийн багш ажилтныг төрийн үйлчилгээний албан хаагчид тооцохгүй хэмээн зохицуулсан тул орон тооны цомхотгол хийх тухай УИХ-ын 48 дугаар тогтоолд хамрагдаагүй байна;
- Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 6 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ыг үндэслэн МГТИС-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 53 дугаар тушаалаар өдрийн унааны хөнгөлөлт 2000, хоолны хөнгөлөлт 8000 төгрөгөөр тооцож 105,260.7 мянган төгрөгийг зарцуулсан;
- Гадаад томилолтоор Португалийн Лиссабоны их сургууль, Казакстан улсад ISAAC, Франц улсад PCAN2025, Канад улсад “North American Symposium” Олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэхээр, Герман

улсад Олон улсын Герман хэлний багш нарын хуралд оролцох ажлуудад 7 багш, ажилчдад нийт 10,792.8 мянган төгрөг зарцуулсан;

- Уул уурхайн 7 хоног арга хэмжээ, Судалгааны стратеги боловсруулах зардал болон Өмнөговь аймгийн Боловсролын газартай хамтарсан хурал зохион байгуулахад 1,150.0 мянган төгрөг, танилцах дадлагын хичээлийн зардалд 3,032.0 мянган төгрөг зарцуулсан;
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал санхүүжүүлээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тус сургуулийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 786,122.5 мянган төгрөгийн 43 худалдан авалт төлөвлөснөөс 267,240.0 мянган төгрөгийн 33 төрлийн шууд худалдан авалт гэрээ хийсэн. Харьцуулалтын аргаар 466,882.00 төгрөгийн нийт 8 тендер зарлаж, худалдан авалт хийсэн байна. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 97.6 хувьтай байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Ш.Нарантуяа гүйцэтгэж, захирал Д.Баатарсайхан анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Булганчимэг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарыг хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,341,553.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 95,123.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагад хамааралтай 29 заалтыг сонгож горим, сорил хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжүүлсэн горим сорилтой холбоотой зөрчил илрээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8-д заасныг болон бусад зүйлийг түүвэрлэн авч үзэхэд оруулбал зохих нийт 183 мэдээлэл мэдээлэхээс 177 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, 1 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан, 5 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, авлага, зардлын данснуудад горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар илэрсэн 1,330,654.2 мянган төгрөгийн 9 алдааг залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар хуульд заагдаагүй урамшуулал олгосонтой холбоотой 500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлүүдтэй холбоотой 75,194.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн нь бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	500.0	1	500.0	100.0
Албан шаардлага	3	75,194.2	3	75,194.2	100.0
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>75,694.2</b>	<b>4</b>	<b>75,694.2</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 624,246.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг залруулсан.

Залруулсан алдаа:

- Тайлант оны үндсэн үйл ажиллагааны орлогыг 121,501.8 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийсэн;
- Цалингийн зардал дансанд НДШ, ХХОАТ-ын 38,909.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэсэн;
- Түрээсийн төлбөрийн өглөгийг 3,060.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Санхүүгийн тайланд 32,179.6 мянган төгрөгийн авлагыг буруу илэрхийлсэн;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг НБББББ-т тусгагдсан ашиглалтын хугацаанаас зөрүүтэй тооцож 140,005.8 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Харилцагчийн нэрийг давхардуулан бүртгэж 288,590.0 мянган төгрөгийн өр төлбөрийг сөрөг утгатайгаар илэрхийлсэн зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцэхгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 41,681.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 41,681.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Шатахууны бүртгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд зарцуулсан шатахууны тооцоог хянахад 23,508.8 мянган төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй, жолоочийн замын хуудас хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн замын хуудсыг хөтөлж, шатахууны тооцоог бодож, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан ажиллах

## 2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн журналаар гарсан зардлыг и баримттай тулган баталгаажуулахад анхан шатны баримтаар нотлогдоогүй 8,756.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй байх.

## 3. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд тусгагдсан цалингийн зардлыг 9,415.8 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд илүү илэрхийлсэн

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд бүрэн тайлагнаж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Орлогыг дутуу илэрхийлсэн.	1	121,501.8			1	121,501.8	1	121,501.8				
2	Элэгдлийн зардлыг илүү илэрхийлсэн	1	140,005.8			1	140,005.8	1	140,005.8				
3	Татвар, НДШ-ийн өглөгийг илүү илэрхийлсэн	1	38,909.0			1	38,909.0	1	38,909.0				
4	Сөрөг утгатай өглөг тайлагнасан	1	288,590.0			1	288,590.0	1	288,590.0				
5	Түрээсийн өглөгийг дутуу тайлагнасан	1	3,060.0			1	3,060.0	1	3,060.0				
6	Авлагыг илүү илэрхийлсэн	1	32,179.6			1	32,179.6	1	32,179.6				
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>624,246.2</b>			<b>6</b>	<b>624,246.2</b>	<b>6</b>	<b>624,246.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан		Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны		
1	Жолоочийн замын хуудасгүй, шатахууны тооцоо бодоогүй	1	23,508.8					1	23,508.8				
2	Зардлыг илүү тайлагнасан	1	9,415.8					1	9,415.8				
3	И баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн	1	8,756.8					1	8,756.8				
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>41,681.4</b>					<b>3</b>	<b>41,681.4</b>				